ГОЛОМТ БАНК
*Сайн сайхныг санхүүжүүлнэ*

# Интернэт банк

Харилцагч та **www.egolomt.mn** вэбсайтаар дамжуулан интернэтэд холбогдсон дурын төхөөрөмжөөс Голомт банкны үйлчилгээг зайнаас, түргэн шуурхай авах боломжтой.

## ҮНДСЭН НҮҮР ХУУДАС




Одоогийн байдлаар Голомт банкны нийт 100 гаруй төрлийн үйлчилгээ Интернэт банканд нэвтрээд байна.

Интернэт банкны нүүр хуудаснаас 10 гаруй төрлийн үйлчилгээг шууд авах боломжтой.



- Бүртгүүлэх /Голомт банканд данстай бол зайнаас бүртгүүлэн Интернэт банк, SocialPay үйлчилгээг авах боломжтой/
- Нэвтрэх нэр, нууц үг сэргээх болон блок гаргах
- Хаяг байршил харах
- Валютын ханш харах
- Тооцоолуур
- Чатбот болон лавлах утас руу холбогдох
- Хэлээ солих
- Тодорхойлолт баталгаа баталгаажуулах
- Түгээмэл асуулт хариулт харах
- Гарын авлага харах
- Лоялти веб сайт руу орох
- Үндсэн вэб сайт руу орох

# Боломжууд

## Гүйлгээ

- Өөрийн данс хооронд гүйлгээ хийх
- Голомт банк дотор гүйлгээ хийх
- Банк хооронд гүйлгээ хийх
- Гадаад шилжүүлэг хийх
- Кредит картын төлбөр төлөх
- Зээлийн төлбөр төлөх
- Захиалгат шилжүүлэг хийх

## Бусад: Хувийн тохиргоо цэс

- Хувийн мэдээллээ өөрчлөх / Банканд бүртгэлтэй и-мэйл, утасны дугаараа өөрчлөх/
- Сонордуулга харах
- Хандалтын түүх харах
- Нэвтрэх нэр солих, нууц үг солих
- Давхар баталгаажуулалт хийх

## Харилцах данс

- Данс нээх, хаах
- Дансны эрхийн тохиргоо
- Дансны хуулга харах, татах / эксел, форматгүй эксел хуулга, pdf, блокчейн хуулга/

## Карт

- Карт захиалах /MNT, USD, CNY/
- Картын пин код шинээр авах /Зураг оруулах/
- Кредит картын төлбөр төлөх
- Дебит карт нөхөн авах
- Дебит карт сунгах /Зураг оруулах/

## Нэмэлт үйлчилгээ

- Изи инфо
- Онлайн тодорхойлолт
- Мобайл банк
- Хувьцаа,арилжаа

## Хувьцаа арилжаа

- Үнэт цаасны данс нээх хүсэлт илгээх
- Үнэт цаасны данс цэнэглэх
- Захиалга өгөх

## Зээл

- Зээлийн төлбөр төлөх
- Зээл хаах
- Дижитал зээл авах
- Хадгаламж барьцаалсан зээл авах

## Төлбөр

- Хэрэглээний төлбөр төлөх
- Нэгж дата авах
- Гаалийн төлбөр төлөх
- Торгуулийн төлбөр төлөх

## Хадгаламж

- Хадгаламж нээх, хаах, сунгах
- Авто сунгалт хийх

## Мерчант

- КҮБ хуулга

# Хэрхэн хэрэглэгч болох вэ?

Та Голомт банкны данстай бол онлайнаар Интернэт банкны үйлчилгээнд бүртгүүлэх боломжтой. Харин дансгүй тохиолдолд та өөрт ойр байрлах дурын салбарт хандан данс нээлгээд Интернэт банкны үйлчилгээнд бүртгүүлээрэй.

Мөн 7-17 насны хүүхдэд Интернэт банкны үйлчилгээг эцэг эх, асран хамгаалагчийн хүсэлтэд үндэслэн дансны үлдэгдэл шалгах болон 300,000 – 500,000₮ хүртэлх дүнтэй гүйлгээ хийх эрхтэйгээр нээлгэх боломжтой.

QR кодыг уншуулан Голомт банкны интернэт банкны нэвтрэх нүүр хуудас руу орно.

Холбоос: **https://www.egolomt.mn**

## Үйлчилгээний нөхцөл

| Үйлчилгээний төрөл | Хураамж |
|---|---|
| Жилийн хураамж | 0₮ |
| Өдрийн гүйлгээний лимит | - 20сая<br>- 500 сая төгрөг хүртэл<br>/Эрх нэмэгдүүлэх хүсэлтийн дагуу/<br>- 500 саяас дээш тусгай эрх |
| Өөрийн данс хооронд шилжүүлэг хийх | 0₮ |
| Голомт хооронд шилжүүлэг хийх | 100₮ |
| Банк хооронд шилжүүлэг хийх | 5,000,000₮ хүртэл 200₮<br>5,000,000₮-с дээш 400₮ |
| Токен төхөөрөмж | 40,000₮ /20сая төгрөгөөс дээш гүйлгээ хийх үед заавал ашиглах шаардлагатай/ |
| Онлайн тодорхойлолт | 1000₮ |

# Танд санал болгох үйлчилгээ






“Онлайн тодорхойлолт”-ыг та харилцах болон хадгаламжийн дансны Данс эзэмшигчийн тодорхойлолт, Дансны үлдэгдлийн тодорхойлолт, Дансны гүйлгээний тодорхойлолтыг Англи болон Монгол хэлээр хамтрангийн төрлөө сонгоод авах боломжтой.

/Данс нээснээс хойш 14 хоног дотор 33000₮, үүнээс хойшхи хугацаанд 1000₮/

Тодорхойлолтоо баталгажуулахыг хүсвэл **https://www.egolomt.mn/reference/guarantee** орон баталгаажуулах боломжтой.

# Аюулгүй байдал

## Бүртгэлгүй төхөөрөмж

Харилцагч та өмнө нь огт ашиглаж байгаагүй төхөөрөмжөөс Интернэт банк болон Смарт банк аппликэйшн руу нэвтрэх үед бүртгэлгүй төхөөрөмжийн баталгаажуулалт хийх бөгөөд санхүүгийн эрсдэлээс хамгаалах зорилготой юм. Та өөрийн хандаж буй шинэ төхөөрөмжийг сануулсны дараа дахин нэвтрэх үед баталгаажуулалт шаардахгүй.

## Давхар баталгаажуулалт

Давхар баталгаажуулалт гэдэг нь харилцагч Интернэт банк руу нэвтрэх болон гүйлгээ хийх үедээ 6 оронтой баталгаажуулах код ашиглагдах үйлчилгээ бөгөөд таныг хамгаалах нууцлалын тохиргоо юм.

### Google authenticator

Гүйлгээний лимитээс үл хамааран харилцагч интернет банкиндаа холбох боломжтой. Google authenticator аппликэйшн суулган ашиглах ба Интернэт банкны “Хувийн тохиргоо – Давхар баталгаажуулалт” цэс рүү орж идэвхжүүлэн ашиглана.

### Е-токен төхөөрөмж

20 сая төгрөгөөс дээш эрхтэй харилцагч салбарт хандаж авах боломжтой. Э-токен төхөөрөмжийн 6 оронтой тоо 60 секунд бүрд солигддог, дахин давтагдашгүй тоо бөгөөд таныг эрсдэлээс хамгаалах нууцлалын төхөөрөмж юм. Харилцагч та өөрийн интернэт банкны нэвтрэх нэр, нууц үгийг хийж нэвтрэх товч дарсны дараа Э-токен төхөөрөмжийн 6 оронтой дугаарыг оруулан баталгаажуулсны дараа нэвтэрнэ. Та өөрт ойр байрлах дурын салбарт хандан төхөөрөмжийг авах боломжтой. Төхөөрөмжийн үнэ: 40,000₮